



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

20210414 № 05/4344
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

СҮХБААТАР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.АМАРБАТ ТАНАА

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Чулуунбаатарын Ариунсанаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Ч.Ариунсанаагийн томилогдохоор нэр дэвшсэн албан тушаалын тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагын "төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх, дэс болон туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан түршлагатай байх" гэснийг хангаагүй тул Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн томилно уу.

Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Х.ХАШБААТАР

УХА0422 5120829